



ᠬᠢᠨᠠᠯᠲᠤ ᠰᠠᠯᠭᠠᠯᠲᠤ
ᠠᠵᠤᠯᠠᠨ ᠰᠠᠷᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡ

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН САРЫН МЭДЭЭ

(2021 оны 12 дугаар сар)

АГУУЛГА

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСГИЙН МЭДЭЭЛЭЛ

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

2.1. ТҮР ХОРОО

2.2. УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР
БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

2.3. БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН
АЖЛЫН ХЭСЭГ

2.3.1. Үйл ажиллагаа үргэлжилсэн ажлын
хэсэг

2.4. ДЭД ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН
АЖЛЫН ХЭСЭГ

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТ

3.1. АСУУЛГА

3.2. АСУУЛГЫН ХАРИУ

3.3. АСУУЛГЫН ХАРИУГ ХЭЛЭЛЦСЭН МЭДЭЭЛЭЛ

3.4. АСУУЛТ

3.5. АСУУЛТЫН ХАРИУ

ДӨРӨВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

4.1. ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

4.2. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ



НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСГИЙН МЭДЭЭЛЭЛ


2021 оны 12 дугаар сарын байдлаар хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий 2 түр хороо, 19 ажлын хэсэгт давхардсан тоогоор Улсын Их Хурлын 148 гишүүн ажилласан байна.

Үүнээс:

- Түр хороо 2;
- УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан 4;
- Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан 14;
- Дэд хорооны тогтоолоор байгуулагдсан 1 ажлын хэсэг байна.

График 1. Хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан нийт ажлын хэсгийн статистик мэдээ /байгуулагдсан хугацаагаар/

- 2020 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан (7)
- 2020 оны намрын чуулганы завсарлагааны хугацаанд байгуулагдсан (2)
- 2021 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан (6)
- 2021 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан (6)



Хүснэгт 1. Хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан нийт ажлын хэсгийн статистик мэдээ /тогтоол, захирамж, шийдвэрийн төрлөөр/

Хугацаа	Түр хороо	УИХ-ын даргын захирамж	Байнгын хорооны тогтоол	Дэд хорооны тогтоол
2020 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан	1	-	5	1
2020 оны намрын ээлжит чуулганы завсарлагааны хугацаанд байгуулагдсан	-	2	-	-
2021 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан	1	2	3	-
2021 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан	-	-	6	-
Нийт - 21	2	4	14	1

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ


2.1. ТҮР ХОРОО

2021 оны 12 дугаар сард Улсын Их Хурлын тогтоолоор тодорхой асуудлыг шалган судалж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий дараах Түр хороод үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 2. Улсын Их Хурлын тогтоолоор байгуулагдсан Түр хороо

Д/д	Түр хороо байгуулсан тогтоол	Түр хорооны бүрэлдэхүүн
1.	2020.10.29 №31 Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай УИХ-ын тогтоол /КОВИД-19/	Түр хорооны дарга: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр Түр хорооны гишүүд: УИХ-ын гишүүн С.Бямбацогт - ХЗБХ, Б.Жавхлан - ТБХ, Н.Учрал - ИЦББХ, Ж.Мөнхбат - БСШУСБХ, Х.Болорчулуун - БОХХААБХ, М.Оюунчимэг - НББХ, Б.Бат-Эрдэнэ - ЁЗСХБХ, Л.Энх-Амгалан - ТББХ, Б.Чойжилсүрэн - ҮББХ, Ж.Ганбаатар - ЭЗБХ-ны дарга нар болон Б.Бейсен - УИХ дахь АН-ын төлөөлөл, С.Ганбаатар - УИХ дахь "Та бидний эвсэл"-ийн төлөөлөл, Т.Доржханд - УИХ дахь "Зөв хүн электорат эвсэл"-ийн төлөөлөл, Н.Алтанхуяг - Бие даагч ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Ц.Рэнцэнтогтох, Х.Хэрлэн
2.	2021.03.26 №30 Түр хороог байгуулах тухай УИХ-ын тогтоол /Оюу толгой/	Түр хорооны дарга: УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэн Түр хорооны гишүүд: УИХ-ын гишүүн Ш.Адьяа, Н.Алтанхуяг, П.Анужин, Ё.Баатарбилэг, Б.Энхбаяр, Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Г.Ганболд, Н.Ганибал, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Б.Дэлгэрсайхан, Б.Жаргалмаа, Ж.Мөнхбат, Ц.Сандаг-Очир, Ж.Сүхбаатар, Г.Тэмүүлэн, Ч.Ундрам, С.Чинзориг ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх М.Солонго, референт Д.Гэрэлт-Од

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4-т дэх заалт



1. Улсын Их Хурлын 2020 оны 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол УИХ-ын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороогоор дараах асуудлыг хэлэлцэв.

- Түр хороо 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Нийгмийн бодлогын байнгын хороотой хамтарсан хуралдаанаар Коронавируст халдвар /КОВИД-19/-ын "Омикрон" хувилбарын талаарх мэдээллийг сонссон.

2. Улсын Их Хурлын 2021 оны 30 дугаар тогтоолоор байгуулагдсан "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" Монгол Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай бол санал боловсруулж, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хороогоор дараах асуудлуудыг хэлэлцэв.

- 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн "Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг хангуулах арга хэмжээний тухай" тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлаар хаалттай хуралдсан.

- 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар "Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай" тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, үдээс хойш Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар эцсийн хэлэлцүүлгийг хийсэн.



ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

2.2. УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН НИЙТ АЖЛЫН ХЭСЭГ

Хүснэгт 3. Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг

Д/д	Ажлын хэсэг байгуулсан захирамж	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
1.	2021.03.02 №16 ЗАХИРАМЖ Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, Б.Жаргалмаа, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Х.Хэрлэн
2.	2021.03.11 №18 ЗАХИРАМЖ Концессын тухай хууль тогтоомж, гэрээний хэрэгжилтийг Дарханы төмөрлөгийн үйлдвэрт хэрхэн хэрэгжүүлж байгааг шалгах, санал, дүгнэлт гарган, шийдвэрийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Г.Дамдинням Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, Ч.Ундром, Х.Ганхуяг, Д.Өнөрболор, Г.Тэмүүлэн, Х.Болорчулуун, О.Цогтгэрэл ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Референт Д.Гэрэлт-Од, С.Төрмөнх
3.	2021.03.18 №21 ЗАХИРАМЖ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор газар эзэмших, ашиглахтай холбоотой газрын харилцааг зохицуулсан хууль тогтоомж болон Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Мөнхбат Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ш.Адъяаа, П.Анужин, Б.Бат-Эрдэнэ, Б.Жаргалмаа ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт К.Пүрэвсүрэн
4.	2021.05.10 №33 ЗАХИРАМЖ Улс төрийн нөхцөл байдалтай холбогдуулан Улсын Их Хурлаас баталсан холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг шалгаж санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил Ажлын хэсгийн дэд ахлагч: УИХ-ын гишүүн Н.Ганибал Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ж.Батсуурь, Ц.Мөнхцэцэг, Ц.Туваан, Ц.Сандаг-Очир ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2021 оны 12 дугаар сард ажилласан талаарх мэдээлэл



1. Улсын Их Хурлын даргын 2021 оны 16 дугаар захирамжаар байгуулагдсан **1.** Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсэг ЭМЯ, ХӨСҮТ-өөс дархлаажуулалтын талаарх мэдээллийг өдөр тутам цахимаар хүлээн авч байна.

- Ажлын дэд хэсэг ЭМЯ, ХӨСҮТ, НОК, УОК-ын дэргэдэх Эрдэмтдийн зөвлөлөөс гаргаж байгаа мэдээллийг тогтмол авч, ажлын хэсгийн гишүүдийг мэдээллээр ханган ажиллаж байна.
- Улсын хэмжээнд 2021 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг вакцины зорилтот бүлгийн 1 дүгээр тунгийн хамралт 96,1 хувь, 2 дугаар тунгийн хамралт 91,8 хувь, 3 дугаар тунгийн хамралт 47,5 хувь, нийт хүн амын 1 дүгээр тунд 69,7 хувь, 2 дугаар тунд 66,5 хувь, 3 дугаар тунд 28 хувь нь тус тус хамрагдсан байна. Өссөн дүнгээр нийт 909,738 хүн 3 дугаар тунд хамрагдсан байна.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

2.3. БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН НИЙТ АЖЛЫН ХЭСЭГ

Хүснэгт 4. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
Төсвийн байнгын хороо		
1	2020.11.04 №05 ТОГТООЛ Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийж, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Х.Булгантуяа Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, Х.Баделхан, Ж.Батсуурь, Г.Тэмүүлэн, Б.Чойжилсүрэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: ТХШХ-ийн ажилтнууд
2	2020.12.30 №07 ТОГТООЛ Төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилт, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 5.1.3, 8.3.15 дахь дэд заалтын биелэлтэд хяналт тавих зорилгоор төсвийн ерөнхийлөн захирагч болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2019-2020 оны үйл ажиллагааг хамруулан шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн С.Ганбаатар Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн С.Амарсайхан, Ц.Анандбазар, Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх М.Солонго, референт Д.Гэрэлт-Од
3	2021.01.20 №01 ТОГТООЛ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын (Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай) хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ц.Анандбазар, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Л.Мөнхбаатар, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх М.Солонго, референт Д.Гэрэлт-Од
Хууль зүйн байнгын хороо		
4	2020.12.24 №09 ТОГТООЛ Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн С.Амарсайхан, С.Бямбацогт, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Д.Отгонбаатар
5	2021.03.15 №07 ТОГТООЛ Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил, Г.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг
6	2021.03.15 №08 ТОГТООЛ Гүйцэтгэх ажлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах явцад хүний үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, хариуцлага тооцох чиглэлээр хэрхэн ажиллаж байгаад үнэлгээ хийж, санал, дүгнэлт гаргах, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Энхбаяр Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг, С.Бямбацогт, Д.Ганбат, Б.Энх-Амгалан ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын болон Төсвийн байнгын хорооны хамтарсан		
7	2021.05.25 №06/03 ТОГТООЛ "Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын 2021 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны явц байдалтай танилцан, шалгаж, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Х.Ганхуяг Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн А.Адьяасүрэн, Г.Амартүвшин, П.Анужин, Г.Мөнхцэцэг, Т.Энхтүвшин ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Референт С.Төрмөнх

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо

8	<p>2021.01.13 №01 ТОГТООЛ</p> <p>Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 39 дүгээр тогтоолын 1.5 дахь дэд заалт "төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг "Эрдэнэт" ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах" гэж заасны хэрэгжилтийг хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Баярсайхан</p> <p>Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн П.Анужин, Ё.Баатарбилэг, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг, Д.Өнөрболор, Ч.Ундрам, Т.Энхтүвшин</p> <p>ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт К.Пүрэвсүрэн</p>
---	---	---

Эдийн засгийн байнгын хороо

9	<p>2021.10.27 №13 ТОГТООЛ</p> <p>"Дархан-Улаанбаатар хот хоорондын автозам барих, ажлын явцыг эрчимжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, тодорхой асуудлаар үүрэг, чиглэл өгөх" үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Г.Дамдинням</p> <p>Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ж.Батжаргал, Д.Батлут, Б.Баттөмөр, Ч.Ундрам</p> <p>ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ш.Батцэнгэл, зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Д.Отгонбаатар</p>
10	<p>2021.11.30 №17 ТОГТООЛ</p> <p>"Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгаж, арилжааны банкуудад байршиж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн мөнгөн хөрөнгийг эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гаргах" үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар</p> <p>Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Г.Амартүвшин, Д.Батлут, Х.Булгантуяа, Т.Доржханд</p> <p>ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: ТХШХ-ийн дарга Д.Эрдэнэсамбуу, ахлах зөвлөх Ш.Батцэнгэл, референт Ч.Сарантуяа</p>

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо

11	<p>2021.11.16 №11 ТОГТООЛ</p> <p>"Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн буюу стратегийн хүнс болох улаан буудайн ургацын байдал, нөөц бүрдүүлэлт, борлуулалт, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл, хангалтын байдал, үр шинэчлэлт хангамжийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах" үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ц.Туваан</p> <p>Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Т.Аубакир, Ж.Батжаргал, Н.Ганибал, Г.Дамдинням</p> <p>ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Ц.Рэнцэнтогтох</p>
12	<p>2021.11.16 №12 ТОГТООЛ</p> <p>"Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах" үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ</p> <p>Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Г.Ганболд, Н.Ганибал, Г.Мөнхцэцэг, Г.Тэмүүлэн</p> <p>ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Х.Хэрлэн</p>
13	<p>2021.11.16 №13 ТОГТООЛ</p> <p>"Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах" үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Батжаргал</p> <p>Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Т.Аубакир, Б.Бейсен, Г.Мөнхцэцэг, Б.Саранчимэг</p> <p>ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Х.Хэрлэн</p>

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо

14	<p>2021.12.24 №03 ТОГТООЛ</p> <p>Газрын тосны салбарын хөрөнгө оруулалт, экспорт, эрэл хайгуул, ашиглалт, олборлолт, байгалийн нөхөн сэргээлтийн асуудлаар газар дээр нь ажиллаж мэдээлэл авах, тулгамдаж буй асуудлыг судлан шийдвэрлэх, холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх зорилгоор Дорнод аймгийн Тамсагбулагийн сав газарт ажиллах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр</p> <p>Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Э.Бат-Амгалан, Д.Ганбат, Н.Наранбаатар, Ц.Сэргэлэн, Б.Энх-Амгалан</p> <p>ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Д.Отгонбаатар, С.Төрмөнх</p>
----	---	---

Монгол Улсын Их Хурлын тухай
хуулийн 39 дүгээр зүйлийн
39.1.7 дахь заалт

2.3.1. Үйл ажиллагаа нь үргэлжилсэн ажлын хэсэг



Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгүүдийн үйл ажиллагаа:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2021 оны 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 39 дүгээр тогтоолын 1.5 дахь дэд заалт “Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг “Эрдэнэт” ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэж заасны хэрэгжилтийг хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:

- 12 дугаар сарын 13-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар ажлын дэд хэсгийн үйл ажиллагааны явцтай танилцаж, холбогдох яамдыг үйл ажиллагаагаа уялдуулж, ажлын явцыг танилцуулахыг үүрэг болгов.
- 12 дугаар сарын 15-ны өдөр ажлын дэд хэсэг Барилга, хот байгуулалтын яаманд хуралдаж, ажлын хэсгийн үйл ажиллагааны явц удааширсан шалтгааныг тодруулан ярилцсан ба түүнийг залруулах талаар санал солилцож, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулахаар тогтсон.

2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2021 оны 11 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн буюу стратегийн хүнс болох улаан буудайн ургацын байдал, нөөц бүрдүүлэлт, борлуулалт, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл, хангалтын байдал, үр шинэчлэлт, хангамжийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:

- 12 дугаар сарын 13-ны өдөр ажлын хэсгийн гишүүд "Милл Хаус" ХХК, "Алтан тариа" ХХК, "Агро Фийд" тэжээлийн үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцав.
- 12 дугаар сарын 15-ны өдөр ажлын хэсгийн хуралдаанаар орон нутагт ажилласан талаар болон гурил, тэжээлийн үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцсан талаарх ажлыг нэгтгэн дүгнэж, ажлын хэсгийн үйл ажиллагааны явцын тайлан, танилцуулгыг хэлэлцэж, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтсон.
- 12 дугаар сарын 16-ны өдрийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанд ажлын хэсгийн явцын талаарх тайланг танилцуулав.

3. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2021 оны 12 дугаар тогтоолоор байгуулагдсан Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:

- 12 дугаар сарын 01-ний өдрийн ажлын дэд хэсгийн хуралдаанаар ажлын хэсгийн удирдамж, ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнийг эцэслэн хэлэлцэж, ажлын хэсгийн ахлагчаар батлуулахаар тогтов.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас холбогдох мэдээллийг авахаар албан бичиг хүргүүлсэн.
- 12 дугаар сарын 21-ний өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны мэдээллийг сонссон.
- 12 дугаар сарын 28-ны өдөр ажлын хэсгийн гишүүд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мал эмнэлгийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Биокомбинат, Мал эмнэлгийн холбоо, Хэнтий, Говьсүмбэр аймгийн Хөдөө аж ахуйн газар, тус аймгийн малын эмч, малчдын төлөөлөл оролцсон хэлэлцүүлэг хийсэн.



4. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2021 оны 13 дугаар тогтоолоор байгуулагдсан Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:

- 12 дугаар сарын 02-ны өдрийн ажлын дэд хэсгийн хуралдаанаар ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн удирдамжийг эцэслэн хэлэлцэж, батлав.
- 12 дугаар сарын 20-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэдээллийг сонссон.
- 12 дугаар сарын 30-ны өдрийн ажлын дэд хэсгийн хуралдаанаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн материалуудтай танилцаад, ажлын хэсгийн гишүүдийн орон нутагт ажиллах талаар санал солилцсон. Мөн яамнаас ирүүлсэн тусгай хамгаалалттай газар нутгийн талаар ажлын хэсгийн гишүүдээс тавьсан асуултын хариултыг авч, ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн.



5. Эдийн засгийн байнгын хорооны 2021 оны 17 дугаар тогтоолоор байгуулагдсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудын хэрэгжилтийг хянан шалгаж, арилжааны банкуудад байршиж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн мөнгөн хөрөнгийг эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:

- 12 дугаар сарын 21-30-ны өдрүүдэд ажлын хэсэг 2 удаа хуралдаж, 21-ний өдрийн хурлаар ажлын дэд хэсэг байгуулав. Ажлын дэд хэсгийн гишүүдэд ажлын удирдамж, төлөвлөгөөний төсөл боловсруулах чиглэл өгч, 12 дугаар сарын 22-ны өдрийн 10 цагт Монголбанкны мэдээллийг сонсохоор тогтов.
- 12 дугаар сарын 22-ны өдөр Монголбанкны мэдээллийг ажлын хэсгийн хуралдаанаар сонсов.
- 12 дугаар сарын 30-ны өдөр ажлын хэсэг, ажлын дэд хэсгийн хамтран хэрэгжүүлэх ажлын удирдамж, төлөвлөгөөг боловсруулан ажлын хэсгийн ахлагчаар батлуулан, гишүүдэд цахимаар хүргүүлж, мэдээллээр хангаж ажилласан.

2.4. ДЭД ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН НИЙТ АЖЛЫН ХЭСЭГ

Хүснэгт 5. Улсын Их Хурлын Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
1	2020.10.26 №01 ТОГТООЛ Уурын болон усан халаалтын зуухтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцаж, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Саранчимэг Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Т.Аубакир, Г.Ганболд, Г.Дамдинням, Ц.Туваан ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Ц.Рэнцэнтогтох



2021 оны 12 дугаар сард Улсын Их Хурлын гишүүдээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга нарт тавьсан 2 асуулга, 2 асуултын хариуг ирүүлж, 4 асуулга, 2 асуулт тавьсан байна. Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуулгын хариуг хэлэлцүүлсэн.

3.1. АСУУЛГА

- 12 дугаар сарын 17-ны өдөр УИХ-ын гишүүн Ш.Адъяаагаас Эрчим хүчний сайдад хандаж “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг барьж байгуулахтай холбоотой авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар” тавьсан 46 дугаар асуулга;
- 12 дугаар сарын 17-ны өдөр УИХ-ын гишүүн С.Бямбацогтоос Төрийн албаны зөвлөлийн даргад хандаж “Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар” тавьсан 47 дугаар асуулга;
- 12 дугаар сарын 27-ны өдөр УИХ-ын гишүүн С.Бямбацогт, Х.Болорчулуун, Д.Батлут, Ж.Батжаргал, Г.Мөнхцэцэг, Ч.Ундрам, С.Чинзориг, Т.Энхтүвшин нараас Гадаад харилцааны сайдад хандаж “Гадаад худалдааг эрчимжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар” тавьсан 48 дугаар асуулга;

<http://parliament.mn/n/nh3yn>

- 12 дугаар сарын 30-ны өдөр УИХ-ын гишүүн С.Бямбацогт, Ш.Адъяаа, Н.Ганибал, Н.Наранбаатар, О.Цогтгэрэл, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн, Т.Энхтүвшин нараас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Гадаад худалдааны чиглэлээр байгуулсан олон улсын гэрээний хэрэгжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” тавьсан 49 дүгээр асуулга.

3.2. АСУУЛГЫН ХАРИУ


- УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандан “Улаанбаатар хотын автозамын түгжрэлийн талаар” тавьсан 43 дугаар асуулгын хариуг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн ХЭГ/3127 дугаар албан бичгээр;
- УИХ-ын гишүүн Ш.Адъяаагаас Эрчим хүчний сайдад хандаж “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг барьж байгуулахтай холбоотой авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар” тавьсан 46 дугаар асуулгын хариуг 12 дугаар сарын 31-ний өдрийн а/4649 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн.

3.3. АСУУЛГЫН ХАРИУГ ХЭЛЭЛЦСЭН МЭДЭЭЛЭЛ

- 12 дугаар сарын 10-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар УИХ-ын гишүүн С.Бямбацогтоос Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад хандаж “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх тохиолдолд байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл болон бусад асуудлын талаар” тавьсан 13 дугаар асуулгын хариуг;
- 12 дугаар сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Нийгмийн хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа зарим арга хэмжээний талаар” тавьсан 25 дугаар асуулгын хариуг тус тус хэлэлцсэн.

3.4. АСУУЛТ

- 12 дугаар сарын 06-ны өдөр УИХ-ын гишүүн Б.Жаргалмаагаас Гадаад харилцааны сайдад хандаж “Гадаадад аж төрж буй монгол иргэдийн эрх ашгийг хэрхэн хамгаалж ажиллаж байгаа талаар” тавьсан 44 дүгээр асуулт;
- 12 дугаар сарын 15-ны өдөр УИХ-ын гишүүн Г.Ганболд, Ц.Анандбазар нараас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандаж “Махны үйлдвэр шинээр барих хэрэгцээ шаардлагын талаар” тавьсан 45 дугаар асуулт.



3.5. АСУУЛТЫН ХАРИУ


- 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр УИХ-ын гишүүн Т.Доржхандаас Хууль зүй, дотоод хэргийн сайдад хандаж “Түүх, шашин, соёлыг дэлгэрүүлэх төв “Богд Зонхова” цогцолборын хөрөнгө оруулалт болон бүтээн байгуулалтын ажлын талаар” тавьсан 42 дугаар асуултын хариуг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 01/5407 дугаар албан бичгээр;
- 12 дугаар сарын 15-ны өдөр УИХ-ын гишүүн Г.Ганболд, Ц.Анандбазар нараас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандаж “Махны үйлдвэр шинээр барих хэрэгцээ шаардлагын талаар” тавьсан 45 дугаар асуултын хариуг 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/4176 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн.

ДӨРӨВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ



4.1. ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

- УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнээс 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн УИХ-03/9581 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, тайланг ЕНБД-ын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн ТГ-01/1476 дугаар албан бичгээр хүргүүлсэн.



4.2. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- Улсын Их Хурлын Тамгын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг Тамгын газрын удирдлагад хүргүүлж, дүнг танилцуулсан.